

“ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-ЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2017 оны 6 дугаар
сарын 19-ны өдөр

Улаанбаатар
хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчлэн найруулга/ хуулийн төслийн 270 дугаар зүйлийн 270.3, 270.4 дүгээр зүйлд “шийдвэр гүйцэтгэгч нь эрх зүйн дээд боловсролтой, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, ёс зүйн шалгуур үзүүлэлтийг хангасан шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэн байна”, мөн 270.5-д “шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж тус тус заасан.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг үндэслэн Хууль зүйн сайдын 2010 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тушаалаар “Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг баталж, мөн сайдын 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/87 дугаар тушаалаар дээрх тушаалын 2 дугаар хавсралтад заасан орон тооны бус Мэргэжлийн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоон үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

Шинээр батлагдах хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр “Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн боловсруулав.

Шинээр боловсруулсан журмын төсөлд сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах мэдлэг, чадвар, зан төлөв, ёс зүйн хэлбэрээр дүгнэхээр тусгаж, мэдлэг чадварын шалгалтыг эрх зүйн болон цахим сүлжээний орчинд чадварыг тодорхойлох сорилын хэлбэрээр, зан төлөв, ёс зүйн шалгуурыг тодорхой төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр эссэ бичүүлж, өгөгдлийн хүрээнд тохиолдол шийдвэрлэх журмаар авахаар төсөлд тусгасан.

Мөн “Хууль сахиулах их сургуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-хууль сахиулах ажил хөтөлбөрөөр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн иргэний төгсөлтийн шалгалтын үнэлгээг шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын үнэлгээтэй адилтган үзэх”-ээр, мөн шийдвэр гүйцэтгэгчээр ажиллаж байсан алба хаагч ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд тухайн олгосон эрхийг хүчингүйд тооцох, дахин сонгон шалгаруулалтад хамрагдсны үндсэн дээр эрх олгох онцлог зохицуулалтыг журамласан.

Одоогийн мөрдөгдөж буй журмаар сорилын болон ярилцлагын шалгалтын нийлбэр оноо 75 байхаар доод оноог өндөр тогтоосноор шийдвэр гүйцэтгэгчийн нөөцийн бүрдүүлэлтэд нөлөөлж байгаа тул доод онооны шалгуурыг 70 оноо байхаар бууруулсан, мөн сонгон шалгаруулалтын нөөцийн бүртгэлд авсан комиссын шийдвэр нь 2 жилийн хугацаанд хүчинтэй байхаар Төрийн албаны тухай хуульд нийцүүлсэн болно.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчдыг Шийдвэр гүйцэтгэх газар болон Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрын даргын хамтарсан сургалтын цаг, сэдвийн төлөвлөгөөнд үндэслэн 7 хоногийн анхан шатны сургалтад хамруулахаар заасны гадна шалгаруулалтын онооны дараалал болон дээрх нэгжийн саналыг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн сул тойрогт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тушаалаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах эрх олгохоор санал тусгасан.

Мөн сонгон шалгаруулалт явуулах орон тооны комисст ШШГЕГ-ын дэд даргаар ахлуулсан Хууль зүй, дотоод хэргийн яам, Шийдвэр гүйцэтгэх газар, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн эрх бүхий албан тушаалтны бүрэлдэхүүнтэй байхаар санал боловсрууллаа.

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР